

Дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттулга Төгөлдөр
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, зөвлөмж гаргах, биелэлтэд хяналт тавих, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах;							
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/133 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

					оны хэрэгжилтэд хамаарах 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталснаас 243 арга хэмжээний тайлан, шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2024 оны явцын дундаж үнэлгээ 77.5 хувийн биелэлттэй гарсан. Нийт 94 шалгуур үзүүлэлтийг үндсэн хэрэгжүүлэх 25 байгууллагаас явцын тайланг ирүүлэхээс 12 байгууллага 88 шалгуур үзүүлэлтийн 2024 оны явцын тайланг ирүүлсэн. Үүнээс 18 шалгуур үзүүлэлтийг тайлагнах хугацаа болоогүй, 5 шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй буюу тооцох аргачлал тодорхойгүй тул 65 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дунджаар 62.3 хувьтай үнэлэгдлээ. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 243 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс 580.1 тэрбум төгрөгөөр 67 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжаас 1.277 тэрбум төгрөгөөр 7		
--	--	--	--	--	--	--	--

					арга хэмжээ, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 20.0 тэрбум төгрөгөөр 1 арга хэмжээ, орон нутгийн сангаас 12.6 тэрбум төгрөгөөр 8 арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангаас 145.5 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ, бусад эх үүсвэрээр 6.496.3 тэрбум төгрөгөөр 8 арга хэмжээ тус тус санхүүжигдсэн байна. Нийт төсөл арга хэмжээний үнэлгээг журмын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол 15.6 хувь нь “Үр дүнтэй”, 40.3 хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 38.3 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 5.8 хувь нь “Үр дүнгүй” байна.		
2	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ХҮҮХ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/	Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/133 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. Батлагдсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 59.8	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

					хувийн хэрэгжилттэй гарсан. Үүнээс бүрэн хэрэгжиж дууссан 48 төсөл байгаа бол хангалтгүй буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 38 төсөл байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөл, арга хэмжээнд 2024 онд нийт төсөвт өртгийн 6.8 хувь буюу 3.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 32 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн дүнгийн 87.1 хувь буюу ойролцоогоор 3.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Хавсралт: 1 файл		
3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Тайлангийн тоо	Хөтөлбөрт туссан 17 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 06-р сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2024 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан нийт 28 арга хэмжээний хэрэгжилтэд ХШҮ хийж, хэрэгжилтийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын и-мэйл хаяг monitoring@ags.gov.mn-аар хүргүүлж ажилласан. Арга хэмжээний хэрэгжилт 97.1% тай үнэлэгдсэн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

4	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан.	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалыг нэгтгэн “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулга, холбогдох тайлангийн хамт Хяналт үнэлгээний үндэсний хороонд 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/132 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 194 төсөл арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.1 хувь буюу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн	3-р сар	100%
---	---	----------------	--	---	---	---------	------

					тооцвол, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 20.1 хувь буюу 39 төсөл арга хэмжээ үр дүнтэй, 19.5 хувь буюу 38 төсөл, арга хэмжээ 11 тодорхой үр дүнд хүрсэн, 52.5 хувь буюу 102 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 7.7 хувь буюу 15 төсөл, арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасан хугацаанд буюу 2025 оны 07 дугаар сарын 10-нд ЗГХХГ-т албажуулан хүргүүлэхээр ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
5	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас болон жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цахим системээр тайлагнасан байна.	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар тайлагнан баталгаажуулж, 2025 оны 01-р сарын 15-ны өдрийн 01/132 албан тоотоор ЗГХХГ-т хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	100%

6	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	2024 оны 3 дугаар сарын 15-ны 01/528 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	“Аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийн 2024 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 82.5 хувийн биелэлттэй гарсан бөгөөд нийт 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 38.3 хувь нь “үр дүнтэй” 48.2 хувь нь “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн бол 11.6 хувь нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, “эрчимжүүлэх шаардлагатай”, 1.8 хувь нь “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн. Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 181 аймаг, нийслэлийн хэмжээнд 3.07 их наяд төгрөгийн төсвийг зарцуулахаар төсөвлөж, гүйцэтгэлээр 3.33 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан танилцуулгыг 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 01/677 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%
---	--	----------------	---	---	---	---------------------------	------

					ажилласан. Хавсралт: 1 файл		
7	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2024 онд байгуулах гэрээний төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд санал өгсөн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу санал хүргүүлсэн.	-	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд байгуулах гэрээний төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд санал өгсөн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлохдоо богино хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр тухайн жилд үр дүн нь гарах үзүүлэлт байхаар тодорхойлох талаар Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт санал хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
8	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ,	Тайлангийн тоо	Хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн ба тайланг яамны удирдлагад 2024.06.07-ны өдөр	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ,	2024 онд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 7 төсөл, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 1 төсөл, гадаадын зээлээр хэрэгжсэн 1 төсөл нийт 9 төсөл хэрэгжиж байна. Эдийн засаг, хөгжлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

	хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийнэ		танилцуулсан.	хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж яамны удирдлагад танилцуулсан байна.	яамнаас гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн нийт 9 төслийн 2 төсөл нь "тодорхой үр дүнд хүрсэн" буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй ч, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай, 5 төсөл нь "эрчимжүүлэх шаардлагатай" буюу зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байгаа бол 2 төсөл нь "үр дүнгүй" буюу зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй гэсэн үнэлгээтэй гарлаа. Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2024 онд гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 41.1 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2025 оны 02 сарын 28-ны 01/598 дугаар албан бичгээр		
--	--	--	---------------	--	--	--	--

					Сангийн яаманд хүргүүлсэн.		
9	Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Тайлангийн тоо	Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх" төслийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2024 оны 02 дугаар сарын 29-ны 01/438 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.	Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.6.6-т "Захиргааны байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 7 төсөл, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 1 төсөл, гадаадын зээлээр хэрэгжсэн 1 төсөл нийт 9 төслийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ 2025 оны 02 дугаар сарын 28- ны өдрийн 01/598 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц 41.1 хувьтай байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%
10	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай	Тайлангийн	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай	Эдийн засаг, хөгжлийн сайдын	Эдийн засаг, хөгжлийн сайдаас Засаг дарга нартай	1-р сар, 2-р сар, 3-р	100%

	байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	тоо	байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр холбогдох газарт хүргүүлсэн.	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.	байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд гэрээний гуравдугаар хавсралт дахь "хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-ий дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 86.69 хувьтай үнэлэгдсэн. Тайлан танилцуулгыг 2025-02 дугаар сарын 28-ны өдрийн 01/588 албан тоотоор ЗГХХГ-т хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	сар, 4-р сар	
11	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/4560 дугаартай албан бичгээр Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.7 хувьтай үнэлэгдсэн ба яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" А/269 дугаар тушаалаар тайлант онд 24 зорилтын хүрээнд 142 арга	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

					хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 101, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн хэрэгжилттэй 34, 70 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байсан байна. Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт 99.3 хувьтай үнэлэгдсэн байна.		
12	Харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	Сайдын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, яамны удирдлагад танилцуулсан байна.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын 2025 оны хяналт шалгалт, дотоод аудит хийх ажлын төлөвлөгөөний дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд харьяа байгууллагын /Шинжлэх ухаан технологийн сан, Оюуны өмчийн газар, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн/ үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашид гарч болох эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн үйл ажиллагаа, хууль тогтоомж, бусад журам эрх зүйн актын хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж өгч ажилласан. Тайланг удирдлагад танилцуулж, хувийг байгууллагуудад	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					хүргүүлсэн.		
13	Харьяа байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Байгууллагын 2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2024 оны 5 дугаар сард хяналт шинжилгээ хийж, яамны удирдлагад 5 зөвлөмж бүхий тайланг танилцуулсан.	байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, яамны удирдлагад танилцуулсан байна.	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 1-31-ны хооронд харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд аудит хийж тайланг танилцуулсан. Дотоод аудитаар цаашид гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулах хүрээнд Шинжлэх ухаан технологийн санд 16 зөвлөмж, Оюуны өмчийн газарт 9 зөвлөмж, Уламжлалт анагаах ухааны хүрээлэнд 6 зөвлөмж өгч ажилласан. Хавсралт: 1 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх.	-	-	ЗГХХГ, ЭЗХЯ, Сангийн яам, Удирдлагын академи хамтран зохион байгуулж буй "Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт богино хугацааны цогц хөтөлбөр II дугаар шат "Төрийн бодлого, бодлогын шинжилгээ" танхимын сургалтад 2025 оны 02 дугаар сарын 24-25-ны өдөр хамрагдан сертификат авсан. Баянгол дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас санаачлан монгол улсын сангийн яамтай хамтран зохион байгуулсан үзүүлэх сургалтад 5 сарын 30 өдөр хамрагдсан. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан "Монгол улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс" сэдэвт сургалтад 2025 оны 5 сарын 15-16 өдрүүдэд хамрагдан сертификат авсан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	-	-	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдан "Монгол бичиг" анхан шат хичээлийг судалж 721868 дугаар үнэмлэх авсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх зохих сургалтад хамрагдсан байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх зохих сургалтад хамрагдах	-	-	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж байгаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТЗУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Баясгалан:

Дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттулга Төгөлдөр /

Огноо: 10.15.00.15

